



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2024 оны 05 сарын 24 өдөр

Дугаар 05

Сүхбаатар сум

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн дүнгийн тухай

Төсвийн тухай хуулийн 69.3, Монгол улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 7.7, Сангийн Сайдын 2019 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын хорооны дүрэм”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтыг үндэслэн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн 2024 оны 1 дүгээр улирлын дүнгийн хяналт шалгалтын дүнг хорооны хурлаар хэлэлцээд ТОГТООХ нь:

Нэг. Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас 2024 онд хийх хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу аймгийн Засаг даргын баталсан удирдамжаар “Шилэн дансны тухай” хууль, Загийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын хэрэгжилтэд хяналт шалгалтыг гүйцэтгэхэд аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа нийт 127 байгууллага, орон нутгийн өмчит аж ахуй нэгж газар, тусгай сангийн 2024 оны 1 дүгээр улирлын шилэн дансны мэдээлэл байршуулалтын үр дүн 81.7 хувьтай гарсан тул “Сайжруулах шаардлагатай” гэсэн дүгнэлтийг баталсугай.

Хоёр. Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах улсын байцаагчийн өгсөн албан шаардлага, зөвлөмжийг тогтоосон хугацаанд хэрэгжүүлэн ажиллаж Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд биелэлтийг тайлагнах, цаашид зөрчил дутагдлыг давтан гаргахгүй байхыг Төсвийн төвлөрүүлэн болон Төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай.

Гурав. Дотоод аудитын хорооны тогтоол, аудитын тайлан ажлын баримтуудын хамт холбогдох албан тушаалтанд хүргүүлж тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын хорооны нарийн бичгийн дарга (Т.Мөнхзул)-д үүрэг даалгасугай.

Хорооны дарга  Н.Лхагвадорж
(Аймгийн Засаг дарга)



4324009005

Нарийн бичгийн дарга:



Т.Мөнхзул

(Ахлах дотоод аудитор)

Гишүүд:



Т.Одсүрэн

(Санхүүгийн хяналт, дотоод
аудитын албаны дарга)



Ө.Сувдаа

(Аймгийн Засаг даргын
Тамгын газрын дарга)



Х.Мөнхжаргал

(Санхүү төрийн сангийн хэлтсийн
даргын албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч)



А.Дашбат

(Иргэний төлөөлөл)